



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/94/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням:

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	18
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БУУЦАГААН СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БҮРНЭЭБААТАР
ТАНАА

2021.02.25 № 2/171

танай _____ -ны № _____ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага нь Сумын Засаг даргатай гэрээ байгуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно.

2021 А4 ТООТ

• 005020208

- Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн;
- Өмнөх оны зөвлөмж, албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй;
- Кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайланг холбогдох журам, стандартын бэлтгэж гаргаагүй;
- Анхан шатны баримтыг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮДЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>129,576,970.09</u>	<u>130,548,057.50</u>
33	АВЛАГА	1,201,781.09	636,989.50
335	Бусад авлага	1,201,781.09	636,989.50
3351	Байгууллагаас авах авлага	1,201,781.09	636,989.50
35	БАРАА МАТЕРИАЛ	128,375,189.00	129,911,068.00
351	Түүхий эд материал	18,608,000.00	28,111,830.00
35110	Тусгай зориулалттай материал	18,608,000.00	28,111,830.00
354	Хангамжийн материал	109,767,189.00	101,799,238.00
35410	Бичиг хэргийн материал	4,484,638.00	3,704,838.00
35440	Түлш, шатах тослох материал	3,380,431.00	300,000.00
35450	Барилгын засварын материал	747,000.00	747,000.00
35460	Хүнсний материал	349,700.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	100,805,420.00	97,047,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,150,167,274.81</u>	<u>2,758,417,302.05</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,150,167,274.81	2,758,417,302.05
392	Биет хөрөнгө	3,130,205,379.15	2,740,341,677.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,617,097,219.81	4,642,835,047.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,821,836,852.10	-2,167,360,240.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	287,380,500.00	287,380,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-108,255,351.08	-149,479,006.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,501,548.00	185,994,068.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-138,570,900.50	-165,685,850.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,377,795.00	96,933,595.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,000,000.00	7,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	100,661,520.00	111,661,520.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-34,218,873.84	-43,169,823.98
393	Биет бус хөрөнгө	19,961,895.66	18,075,625.00
39301	Програм хангамж	13,978,000.00	13,978,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-12,016,104.34	-13,902,375.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,279,744,244.90</u>	<u>2,888,965,359.55</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,177,634.12</u>	<u>2,113,480.96</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,177,634.12	2,113,480.96
413	Өглөг	2,177,634.12	2,113,480.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,088,121.12	1,046,923.55
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,089,513.00	1,066,557.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,277,566,610.78</u>	<u>2,886,851,878.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,277,566,610.78	2,886,851,878.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	520,400,904.00	520,400,904.00
51101	Өмч: - төрийн	520,400,904.00	520,400,904.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,337,982,600.59	1,947,267,868.40
51210	Өмнөх үеийн үр дүн	2,337,982,600.59	2,337,982,600.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-390,714,732.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	419,183,106.19	419,183,106.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,279,744,244.90</u>	<u>2,888,965,359.55</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлан оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	725,034,900.00	574,598,537.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	332,129,096.00	83,222,934.00
120	Нийтлэг татварын бус орлого	332,129,096.00	83,222,934.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	332,129,096.00	83,222,934.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	579,900.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	331,549,196.00	82,222,934.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	392,905,804.00	491,375,603.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,899,104.00	70,940,403.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,794,104.00	43,797,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	27,142,755.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	350,006,700.00	420,435,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	350,006,700.00	420,435,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	806,686,178.72	965,313,269.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	806,686,178.72	965,313,269.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,021,840.72	903,627,163.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,041,722.00	241,868,644.97
210101	Үндсэн цалин	206,041,722.00	241,868,644.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,657,461.13	30,810,381.10
210201	Тэтгэврийн даатгал	18,512,271.73	21,011,667.87
210202	Тэтгэмжийн даатгал	1,813,246.85	2,459,330.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,450,598.68	1,970,824.53
210204	Ажилгүйдлийн даатгал	352,849.17	487,327.36
210205	Эрүүл мэндийн даатгал	3,528,494.70	4,881,230.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,871,138.00	32,445,980.68
210301	Гэрэл, цахилгаан	6,414,538.00	6,711,480.68
210302	Түлш, халаалт	29,456,600.00	25,734,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,432,770.22	40,090,032.45
210401	Бичиг хэрэг	2,494,350.00	5,888,400.00
210402	Тээвэр, шатахуун	23,353,770.22	26,843,062.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,172,000.00	2,129,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	4,980,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	412,650.00	248,700.00
2105	Нормативт зардал	00.00	349,700.00
210502	Хоол, хүнс	00.00	349,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,192,700.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	206,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,986,700.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	18,581,150.00	4,944,000.00
210701	Гадаад албан томилолт	42,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	9,284,500.00	4,794,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,254,650.00	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,229,426.00	86,883,084.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,197,426.00	85,098,084.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,782,000.00	1,485,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	457,015,473.37	466,235,340.76

**Бууцаган сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,283,000.69	32,699,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	444,282,472.68	433,536,120.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,664,338.00	61,686,105.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	29,955,745.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,382,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	6,573,145.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,164,338.00	31,730,360.73
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	00.00	6,490,093.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,164,338.00	25,240,267.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-81,651,278.72	-390,714,732.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	45,682,797.86	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	29,472,797.86	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	16,210,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-45,682,797.86	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-127,334,076.58	-390,714,732.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	393,485,704.00	492,375,603.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	579,900.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	579,900.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	579,900.00	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	579,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	392,905,804.00	491,375,603.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,899,104.00	70,940,403.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,794,104.00	43,797,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	27,142,755.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	350,006,700.00	420,435,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	350,006,700.00	420,435,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	388,915,704.00	486,819,803.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	388,915,704.00	486,819,803.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,151,366.00	425,133,697.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197,516,502.00	229,956,064.66
210101	Үндсэн цалин	197,516,502.00	226,797,364.66
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,158,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,787,100.00	30,369,845.01
210201	Тэтгэврийн даатгал	17,447,900.00	21,194,941.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,084,700.00	2,323,762.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,667,800.00	1,774,428.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,000.00	461,393.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,169,700.00	4,615,321.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,501,900.00	30,502,496.15

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210301	Гэрэл, цахилгаан	8,045,300.00	4,767,996.15
210302	Түлш, халаалт	29,456,600.00	25,734,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,115,600.00	27,723,606.45
210401	Бичиг хэрэг	3,948,500.00	4,331,600.00
210402	Тээвэр, шатахуун	22,663,100.00	21,799,206.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	984,000.00	634,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,220,000.00	598,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,515,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,215,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	18,392,500.00	4,944,000.00
210702	Дотоод албан томилолт	9,326,500.00	4,944,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,066,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,526,764.00	75,097,410.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,556,764.00	71,383,410.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,970,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,796,000.00	26,540,275.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,696,000.00	25,540,275.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,764,338.00	61,686,105.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	29,955,745.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,382,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	6,573,145.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,164,338.00	31,730,360.73
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	00.00	6,490,093.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,164,338.00	25,240,267.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,570,000.00	5,555,800.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,570,000.00	5,555,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,570,000.00	5,555,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,570,000.00	5,555,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,570,000.00	5,555,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,570,000.00	5,555,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,570,000.00	-5,555,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,400,904.00	450,946,187.28	2,433,553,596.07	3,404,900,687.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	31,763,081.09	31,763,081.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,400,904.00	450,946,187.28	2,465,316,677.16	3,436,663,768.44
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-127,890,017.36	-127,890,017.36
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,400,904.00	419,183,106.19	2,337,982,600.59	3,277,566,610.78
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	520,400,904.00	419,183,106.19	2,337,982,600.59	3,277,566,610.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,400,904.00	419,183,106.19	2,337,982,600.59	3,277,566,610.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-390,714,732.19	-390,714,732.19
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,400,904.00	419,183,106.19	1,947,267,868.40	2,886,851,878.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
					/ төгрөгөөр /
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	415,209,000.00	396,194,932.27	19,014,067.73	95.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,209,000.00	396,194,932.27	19,014,067.73	95.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,226,400.00	366,239,187.27	18,987,212.73	95.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,980,900.00	229,956,064.66	3,024,835.34	98.70
210101	Үндсэн цалин	227,787,900.00	226,797,364.66	990,535.34	99.57
210105	Гэрээт ажлын хөлс	5,193,000.00	3,158,700.00	2,034,300.00	60.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,786,200.00	30,369,845.01	1,416,354.99	95.54
210201	Тэтгэврийн даатгал	22,279,700.00	21,194,941.01	1,084,758.99	95.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,376,100.00	2,323,762.00	52,338.00	97.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,900,900.00	1,774,428.00	126,472.00	93.35
210204	Ажилгүйдлийн даатгал	475,700.00	461,393.00	14,307.00	96.99

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210205	Эрүүл мэндийн даатгал	4,753,800.00	4,615,321.00	138,479.00	97.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,580,300.00	30,502,496.15	3,077,803.85	90.83
210301	Гэрэл, цахилгаан	7,845,800.00	4,767,996.15	3,077,803.85	60.77
210302	Түлш, халаалт	25,734,500.00	25,734,500.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,565,600.00	27,723,606.45	4,841,993.55	85.13
210401	Бичиг хэрэг	4,332,500.00	4,331,600.00	900.00	99.98
210402	Тээвэр, шатахуун	25,890,800.00	21,799,206.45	4,091,593.55	84.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,382,300.00	634,000.00	748,300.00	45.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ажуйн эд зүйлс	600,000.00	598,800.00	1,200.00	99.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	534,900.00	-	534,900.00	-
210604	Урсгал засвар	534,900.00	-	534,900.00	-
2107	Томилолт, зочны зардал	10,237,300.00	4,944,000.00	5,293,300.00	48.29
210702	Дотоод албан томилолт	10,237,300.00	4,944,000.00	5,293,300.00	48.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,758,600.00	11,202,900.00	555,700.00	95.27
210802	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,807,600.00	7,488,900.00	318,700.00	95.92
210803	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	150,000.00	150,000.00	50.00
210805	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	-	27,000.00	-
210806	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	-	60,000.00	-
210807	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,782,600.00	31,540,275.00	242,325.00	99.24
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	30,782,600.00	30,540,275.00	242,325.00	99.21
211	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2131	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,982,600.00	29,955,745.00	26,855.00	99.91
213202	Бусад урсгал шилжүүлэг	29,982,600.00	29,955,745.00	26,855.00	99.91
213208	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,382,600.00	23,382,600.00	-	100.00
22	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	6,573,145.00	26,855.00	99.59
1310	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	415,209,000.00	417,343,607.00	(2,134,607.00)	100.51
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	414,209,000.00	416,343,607.00	(2,134,607.00)	100.52
132007	Орон нутгийн төсвөөс	414,209,000.00	416,343,607.00	(2,134,607.00)	100.52
1200041	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
1200042	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
620001	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	22	1.00	95.65
620002	Удирдах ажилтан	09	09	-	100.00
620003	Гүйцэтгэх ажилтан	10	09	1.00	90.00
620004	Үйлчлэх ажилтан	02	02	-	100.00

63	Гэрээт ажилтан	02	02	-	100.00
650001	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	22	1.00	95.65
650002	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	07	06	1.00	85.71
650010	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06	06	-	100.00
650011	Гэрээт ажилтан	02	02	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	08	08	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

				/ төгрөгөөр /	
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	64,450,310.50		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	64,450,310.50		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	64,450,310.50		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	64,450,310.50		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	64,450,310.50		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	64450310.50		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	64,450,310.50		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	37,307,555.00		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	27,142,755.50		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Бүрнээбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны цахим хуудаст мэдээллийг цаг тухайд нь байршуулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.25-ний өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хуулиар олгосон чиг үүргээ нэр төртэй биелүүлж бие даасан байдлыг хангах төлөөлөгчдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж иргэдийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, ажиллаж амьдрах, санаачилж бүтээх, тав тухтай орчныг бүрдүүлэх шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог тогтвортой дээшлүүлж төсөв санхүү, хүний нөөцийн болон үйл ажиллагааны зөрчилгүй сум, хамт олон болох” эрхэм зорилго тавьж ажилласан байна.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын төсвийн захирагчаар 2020.01.01-2020.07.27-ний хооронд Д.Лхагвадорж, 2020.07.28-2020.12.31-ний хооронд Л.Бүрнээбаатар, нягтлан бодогчоор 2020.01.01-2020.02.06-ний хооронд Г.Ууганзаяа, 2020.02.07-2020.03.31-ний хооронд Д.Маньбазар, 2020.04.01.-2020.04.30-ний хооронд З.Саран /хавсран гүйцэтгэсэн/, 2020.05.01-2020.12.01-ний хооронд П.Цэнгэл, 2020.12.02-2020.12.14-ний хооронд З.Саран, 2020.12.15-2021.01.08-ний хооронд Г.Мөнхсүвд нар ажилласан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бууцагаан сумын ЗДТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.

Бууцагаан сумын ЗДТГ нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Аcolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Бууцагаан сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг үр дүнгийн тайлангийн зардлын 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар буюу 12614.4 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 2 хувиар буюу 10129.9 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс 6718.7 мянган төгрөгөөр их байгаа нь 4 дүгээр улиралд зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2888965.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 390778.9 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мян.төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	129,577.0	130,548.1	971.1
Авлага	1,201.8	637.0	(564.8)
Бараа материал	128,375.2	129,911.1	1,535.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,207,098.5	2,824,185.4	(382,913.1)
Үндсэн хөрөнгө	5,321,996.6	5,363,782.7	41,786.1
Хуримтлагдсан элэгдэл	(2,114,898.1)	(2,539,597.3)	(424,699.2)
Нийт хөрөнгө	3,336,675.5	2,954,733.5	(381,942.0)
Өр төлбөр	2,177.6	2,113.5	(64.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,277,566.6	2,886,851.9	(390,714.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,279,744.2	2,888,965.4	(390,778.9)

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд 1201.8 мянган төгрөгийн авлага байснаас гэрэл цахилгаан, бусад зардлын тооцооны авлагыг барагдуулж, “НИК” ХХК-аас авах 636.9 мянган төгрөгийг барагдуулаагүй үлдэгдлээр байгаа боловч тус аж ахуйн нэгжтэй хийсэн тооцоо нийлсэн акт байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 129911.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1535.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн өвс, будаа, барилга байгууламжийн тэмдэг, засварын материал зэрэг 45992.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 5321996.6 мянган төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 5555.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 36230.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй авч, хөрөнгө акталж устгаагүй байна. “Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас 25737.8 мянган төгрөгийн 1 дүгээр багт гүн худаг гарган өгч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 6000.0 мянган төгрөгийн мал угаалгын ванн, Засгийн газраас 4492.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж ирсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 390714.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 2886851.9 мянган төгрөг болсон байна.

Бууцагаан сумын ЗДТГ-ын улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 70428.5 мянган төгрөгөөр буюу 20.1 хувиар өссөн бөгөөд, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг өмнөх онтой адил 1000.0 мянган төгрөгөөр баталжээ.

Нийт зардал өмнөх онд 292717.9 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 75656.9 мянган төгрөгөөр буюу 25.8 хувиар өсөж, 368374.8 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс урсгал шилжүүлгийг 11136.9 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний зардлыг 75656.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд ЗДТГ-ын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 367515.0 мянга, багийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 86018.9 мянга, нийт 453533.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 43332.9 мянган төгрөгөөр бууруулж, 415009.0 мянган төгрөгийг баталсан ба 11 дүгээр сард тээвэр шатахууны зардлыг 200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 415209.0 мянган төгрөгөөр баталжээ.		
Анхны батлагдсан төсөв	2020 оны 12 сард зохицуулалт хийсэн төсөв	
458341.9	415209.0	

Тайлант онд ЗДТГ-т 17, багт 6 орон тоо баталснаас жижүүрийн орон тоо дутуугаас гүйцэтгэлээр 22 орон тоогоор ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 414209.0 мянга, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгаас олгохоор батлагдсан санхүүжилтээс 6226.2 мянган төгрөгөөр илүү буюу 420435.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөгийг оруулж, оны эцэст 25240.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, 396194.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Иймд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар төсвийн хуваарийг нарийвчлан үзэхээр шийдвэрлэв.

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
НИЙТ	415,209.00	396,194.93	19,014.07	95%	
Хөтөлбөр70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	415,209.00	396,194.93	19,014.07	95%
АРГА ХЭМЖЭЭ 80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	270,095.70	252,034.26	18,061.44	93%
АРГА ХЭМЖЭЭ 80106	Баг, хорооны ҮАЗардал	78,730.70	78,008.40	722.30	99%
АРГА ХЭМЖЭЭ 80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	29,382.60	29,382.60	-	100%
АРГА ХЭМЖЭЭ 81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	29,000.00	28,770.30	229.70	99%
АРГА ХЭМЖЭЭ 82212	Хур хог хаягдал, орчны бохирдол	8,000.00	7,999.38	0.63	99%

Эх сурвалж: Э-тайлангаас татагдсан төсвийн хэлбэл, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Сангийн яамны Э-тайланд төлөвлөгөөг зөв оруулаагүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, Э-тайлангийн төсвийн хэлбэлзлээс 919.6 мянган төгрөгөөр зөрүүтэй ба энэ нь томилолтын зардал дээр зөрүү гарсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 70940.4 мянган төгрөгийн орлого оруулсан ба гүйцэтгэлээр 64450.3 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 6490.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 3. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	11	11	11	
2	Хагас жил	4	4	4	
3	Улирал бүр	1	4	4	
4	Сар бүр	3	36	36	
5	Тухай бүр	8	96	95	1
Нийт		27	151	150	1

Шилэн дансанд байршуулах 151 мэдээллээс 130 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 97504.2 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Эх сурвалж: Бууцаган сумын ЗДТГ-ын шилэн данс

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитыг аудитор Н.Бүнчинсүрэн хийж гүйцэтгэн, аудитаар 76793.0 мянган төгрөгийн 13 алдаа зөрчил илэрснээс 5350.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2029.0 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага өгч, 69414.0 мянган төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгчээ.

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, трактор, галын машиныг гэрчилгээжүүлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ба байгууллагын удирдлагад өгсөн 8 зөвлөмжөөс санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тооцоо бодсон актаар баталгаажуулах, бусад хангамжийн материалд үлдэгдлээр байгаа өвсний тооцоог хийх, НБББББ-ийг баталж мөрдөх, нярвын тайланг үнэн зөв тайлагнах зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 57252.5 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 57252.5 мянган төгрөгийн 8 залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2003.2 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 55249.3 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. Сумын Засаг даргын захирамжаар ЗДТГ-ын дарга Б.Лхагвадоржид ажлаас чөлөөлөгдөхөд 4973.1 мянган төгрөгийн 5 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмжийг 2020 оны 07 дугаар сард олгосон ба 11 сард Б.Лхагвадорж нь сумын Засаг даргаар томилогдож, 1243.2 мянган төгрөгийн тэтгэмжийг 12 дугаар сарын цалинтай давхардсан байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын Засаг дарга Б.Лхагвадоржоор 1243,2 мянган төгрөгийг төсөвт нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Сумын Засаг даргын 2020.12.23-ний өдрийн А/148 дугаар захирамжаар "Заг, Гурванбулаг, Жаргалант сумдад отор хийн өвөлжиж байгаа айл өрхийн галлагаа дулааны асуудал хүндэрч гамшгийн нөхцөл үүссэн тул түлээ нүүрсний тусламж үзүүлэх, тээвэрлэх зардалд 1320.0 мянган төгрөг, түүний 50 хувийг буцаан төвлөрүүлэх нөхцөлтэйгөөр зарцуулах" шийдвэр гаргасан байхад тайланд авлагаар тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тусламж үйлчилгээ авсан айл өрхөөр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Сумын Засаг даргын 2020.06.08-ний өдрийн А/10 дугаар захирамжаар ажилтнуудад 1000.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар 100,0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4. Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангитай өвсний тулган баталгаажуулалт хийхэд Бууцагаан суманд 71050.0 мянган төгрөгийн өвс олгож, 23795.0 мянган төгрөгийн өвсний үнийг төлүүлж, 47255.0 мянган төгрөгийн авлагатай тооцоог гаргаж өгсөн байхад сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд өвстэй холбоотой өглөг, авлага байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өвсний тооцоог хийж дуусгах албан шаардлагыг хүргүүлэв.

5. "Элит хөшиг" ХХК-тай 2020.11.10-ны өдөр гэрээ байгуулж, нэг бүр нь 2500.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг авто зогсоолын автомат хаалт авсан байхад үндсэн хөрөнгөд 5000. мянган төгрөгийн үнээр 1 ширхгээр бүртгэжээ.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тоо ширхэг, үнийг залруулж бүртгэх албан шаардлагыг хүргүүлэв.

6. 2020.10.29-ны өдөр Б.Нямжаргалаас авсан 61.0 мянга, 2020.12.29-ны өдөр Б.Энхдалай нэрээр "Таванчимэг" гэсэн падаанаар 142.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар тайлагнасан, "Цэнгэлийн зүг" ХХК-аас авсан 1200.0 мянган төгрөгийн үнэ бүхий ус утаа мананцаруулагч багажийг бараа материалд бүртгэсэн, бараа материалд 12 дугаар сард банштай ногоотой шөл, будаатай шөл, ногоотой шөл бүртгэж зарлагадсан байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг зөв бүртгэх, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг үндсэн хөрөнгөд залруулж бүртгэх албан шаардлагыг хүргүүлэв.

7. Өмнөх оны авлага, өглөгийг барагдуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, нярав кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайлан зөрүүтэй гаргасан.

Шийдвэрлэсэн нь: "Хязгаарлалттай" дүгнэлтийг өгч, өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

8. Тайлант онд байгууллагын нягтлан бодогч 3 удаа солигдсонтой холбоотой 32910.8 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, санхүүгийн баримтад байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

9. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, 71.5 мянган төгрөгөөр архи, бохь худалдан авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

10. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг аудитаар тулган шалгахад 19990.0 мянган төгрөгийн үнэ бүхий 59-49 БНХ улсын бүртгэлийн дугаартай УАЗ-390942-018 маркийн ачааны автомашины гэрчилгээ иргэн С.Тунгалагийн нэр дээр бүртгэлтэй, багийн дарга нар ашиглаж байгаа 9960.0 мянган төгрөгийн 6 ширхэг мотоцикл тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээг авч зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Сум дундын Ойн ангиас авсан өвс тэжээлийг ЗДТГ-ын санхүүгийн тайланд тусгаагүй ба байгууллагын нярваас авсан тайлбар бичгээр нийт 5015 боодол өвс худалдан борлуулж, үлдэгдэлтэй гэсэн тайлбарыг өгсөн тул тус асуудалд цаашид анхаарах шаардлагатай байна.

Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 2018 онд тусгай зориулалтын бараа материал дансанд үлдэгдлээр байгаа 18608.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг үлдэгдлээр байхгүй байхад байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс үлдэгдлээр гаргасан ба энэ асуудал хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байна. Энэ асуудлын шийдвэрлэлтийн талаар манай байгууллагад албан бичгээр хариу ирүүлж ажиллахыг мэдэгдье.

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Бууцаган сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/64/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Бууцаган сумын Засаг даргын Тамгын газар	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сумын Засаг даргын захирамжаар ЗДТГ-ын дарга Б.Лхагвадоржид ажлаас чөлөөлөгдөхөд 4973.1 мянган төгрөгийн 5 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмжийг 2020 оны 07 дугаар сард олгосон ба 11 сард Б.Лхагвадорж нь сумын Засаг даргаар томилогдож, 1243.2 мянган төгрөгийн тэтгэмжийг 12 дугаар сарын цалинтай давхардсан байна.	1243.2	Төлбөрийн акт тогтоов.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
2	Сумын Засаг даргын 2020.12.23-ний өдрийн А/148 дугаар захирамжаар "Заг, Гурванбулаг, Жаргалант сумдад отор хийн өвөлжиж байгаа айл өрхийн галлагаа дулааны асуудал хүндэрч гамшгийн нөхцөл үүссэн тул түлээ нүүрсний тусламж үзүүлэх, тээвэрлэх зардалд 1320.0 мянган төгрөг, түүний 50 хувийг буцаан төвлөрүүлэх нөхцөлтэйгээр зарцуулах" шийдвэр гаргасан байхад тайланд авлагаар тусгаагүй.	660.0	Төлбөрийн акт тогтоов.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
3	Төсвийн хөрөнгөөс 71.5 мянган төгрөгөөр архи, бохь худалдан авсан.	76.3	Төлбөрийн акт тогтоов.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
4	Сумын Засаг даргын 2020.06.08-ний өдрийн А/10 дугаар захирамжаар ажилтнуудад 1000.0 мянган төгрөгийн урамшуулал олгоходоо хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй.	100	Төлбөрийн акт тогтоов.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
5	Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангитай өвсний тулган баталгаажуулалт хийхэд Бууцаган суманд 71050.0 мянган төгрөгийн өвс олгож, 23795.0 мянган төгрөгийн өвсний үнийг төлүүлж, 47255.0 мянган төгрөгийн авлагатай тооцоог	47255.0	Албан шаардлага өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа

**Бууцаган сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	гаргаж өгсөн байхад сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд өвстэй холбоотой өглөг, авлага байхгүй.				
6	"Элит хөшиг" ХХК-тай 2020.11.10-ны өдөр гэрээ байгуулж, нэг бүр нь 2500.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг авто зогсоолын автомат хаалт авсан байхад үндсэн хөрөнгөд 5000.0 мянган төгрөгийн үнээр 1 ширхгээр бүртгэсэн.	5000.0	Албан шаардлага өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
7	2020.10.29-ны өдөр Б.Нямжаргалаас авсан 61.0 мянга, 2020.12.29-ны өдөр Б.Энхдалай нэрээр Таванчимэг гэсэн падаанаар 142.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар тайлагнасан. "Цэнгэлийн зүг" ХХК-аас авсан 1200.0 мянган төгрөгийн үнэ бүхий ус утаа мананцаруулагч багажийг бараа материалд бүртгэсэн, бараа материалд 12 дугаар сард банштай ногоотой шөл, будаатай шөл, ногоотой шөл бүртгэж зарлагдсан.	1374.0	Албан шаардлага өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
8	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, нярав кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайлан зөрүүтэй гаргасан.	0	Албан шаардлага өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
9	Тайлант онд байгууллагын нягтлан бодогч 3 удаа солигдсонтой холбоотой 32910.8 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, санхүүгийн баримтад байхгүй.	32910.8	Албан шаардлага өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
10	Тээврийн хэрэгслийн гэрчилгээг аудитаар тулган шалгахад 19990.0 мянган төгрөгийн үнэ бүхий 59-49 БНХ улсын бүртгэлийн дугаартай УАЗ-390942-018 маркын ачааны автомашины гэрчилгээ иргэн С.Тунгалагийн нэр дээр бүртгэлтэй, багийн дарга нар ашиглаж байгаа 9960.0 мянган төгрөгийн 6 ширхэг мотоцикл тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй	29950.0	Албан шаардлага өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
11	Санхүүгийн тайланд бүртгэлтэй өмнөх оны 553.8 мянган төгрөгийн авлага, 1066.5 мянган төгрөгийн өглөгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1620.3	Зөвлөмж өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
12	Шилэн дансанд байршуулах 130 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 97504.2 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	0	Зөвлөмж өгөв.	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, Г.Ууганзаяа
ДҮН		120189.6			

---oO---